# "'АЛТАН ТУР" ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ "ТҮМЭН ХААН РЕСОРТ АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР" ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

(Регистрийн дугаар – 2703181)

**ХЯНАСАН:**

ХБОБХГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

**БОЛОВСРУУЛСАН:**

"АЛТАН ТУР" ХХК ЗАХИРАЛ Б.АЛТМАА

"АЛТАН ТУР" ХХК
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН О.АЗЗАЯА

# ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ..... 10
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ ..... 13
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 14
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 15
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 18
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 19
8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 19
9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 20
10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 22
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ..... 25
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 27
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 29

**Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1.Төслийн талбайн эргэлтийн цэгийн солбилцолууд ........ 3
Хүснэгт 2. Ундны усны тооцоо ........ 7
Хүснэгт 3. Ногоон байгууламж, зам усалгааны тооцоо ........ 7
Хүснэгт 4. Ашиглах усны хэмжээ ........ 8
Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ........ 15
Хүснэгт 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт ........ 18
Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт ........ 20
Хүснэгт 8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ........ 22
Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний биелэлт ........ 25
Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ........ 27
Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт ........ 29

**Зургийн жагсаалт**

Зураг 1. Төслийн байршлын зураг ........ 3
Зураг 2. Ерөнхий төлөвлөлт ........ 4
Зураг 3. Гэрийн хүчин чадал ........ 5
Зураг 4. Хурлын заал ........ 5
Зураг 5. Ресторан, лаунж ........ 5
Зураг 6. Төслийн гаднах талбай ........ 6
Зураг 7. Цахилгаан хангамж ........ 6
Зураг 8. Худгийн байршил ........ 7
Зураг 9. Гүний худаг ........ 8
Зураг 10. Зам харилцаа төлөвлөлтийн зураг ........ 9

# 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн нэр:** “Түмэн хаан ресорт аялал жуучлалын цогцолбор”

**Төсөл хэрэгжүүлэгч: “**Алтан тур” ХХК /улсын бүртгэлийн дугаар: 9011098031, регистрийн дугаар: 2703181, албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 1-р хороо, 12-р хороолол, 47-7 тоот, утас: 99086928/

**Төслийн байршил:** Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 6-р хорооны нутагт байрлана.

*Хүснэгт 1.Төслийн талбайн эргэлтийн цэгийн солбилцолууд*

| № | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Градус | Минут | Секунд | Градус | Минут | Секунд |
| 1 | 107 | 23 | 18.830 | 47 | 58 | 54.240 |
| 2 | 107 | 23 | 27.800 | 47 | 58 | 54.300 |
| 3 | 107 | 23 | 32.431 | 47 | 58 | 52.797 |
| 4 | 107 | 23 | 38.849 | 47 | 58 | 49.683 |
| 5 | 107 | 23 | 34.365 | 47 | 58 | 46.510 |
| 6 | 107 | 23 | 29.223 | 47 | 58 | 48.706 |
| 7 | 107 | 23 | 18.140 | 47 | 58 | 52.720 |



***Зураг 1. Төслийн байршлын зураг***

**Төслийн хүчин чадал**

**Барилгын ерөнхий үзүүлэлт:** Тус бааз нь төслийн хүрээнд:

- Задгай кино театр
- Авто зогсоол
- Тайз
- Спорт талбай
- Автомашины граж
- Шорлогийн талбай
- A,B,C блок
- Дугуйн амралтын талбай зэргийг нэмж байгуулахаар төлөвлөсөн байна.




***Зураг 2. Ерөнхий төлөвлөлт***

“Түмэн Хаан” бааз нь ерөнхий төлөвлөгөөний дагуу 2022 оны 9 сарын 12-ны байдлаар нийт 32 ширхэг гэрийг амралт үйлчилгээний зориулалтаар ашиглаж байна.

- 2 ортой 1 ширхэг гэр
- 3 ортой 10 гэр
- 4 ортой 19 гэр
- 5 ортой 2 гэр
- 10 ортой 1 гэр



***Зураг 3. Гэрийн хүчин чадал***

"Түмэн Хаан" бааз нь 50 хүний багтаамжтай нэг хурлын заалтай.





***Зураг 4. Хурлын заал***

"Түмэн Хаан" бааз нь нэг дор 84 хүнийг хүлээн авах хүчин чадалтай ресторантай, 4 хүний 6 ширээтэй жижиг лаунжтай.





***Зураг 5. Ресторан, лаунж***

Гадна талбайн хувьд тус бааз нь тоглоомын талбайн боолон 2 ширхэг саравчтай.



***Зураг 6. Төслийн гаднах талбай***

**Төсөл хэрэгжих талбайн дэд бүтэц**

**Цахилгаан хангамж**: "Алтан тур" ХХК-ийн Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хорооны Горхи-Тэрэлжийн нутагт орших "Түмэн хаан ресорт" төслийн талбай нь цахилгаан эрчим хүчний хэрэглээг төвийн эрчим хүчний шугам сүлжээнээс татан авч, бууруулах трансформатороор дамжуулан авч хангадаг.



***Зураг 7. Цахилгаан хангамж***

**Усан хангамж:** Тус төслийн талбай нь усны хэрэгцээг өөрийн эзэмшлийн гүний худгаас хангадаг. Улаанбаатар хотын Эрдэнэдрийлинг компаний супер 6000 маркийн станокоор 70м гүнтэй, 1.2л/сек ундарга бүхий худгийн цооногийг 2007 оны 11 сарын 26 батлуулсан байна.

Эзэмшигч иргэн: Б. Цэцэгмаа

Худаг гаргасан аж ахуйн нэгж: "Эрдэнэдрийлинг"ХХК

Худгийн байршил: 107° 23' 32,57" E , 47° 58 ' 48,34" N




***Зураг 8. Худгийн байршил***

**Ундны усны тооцоо:** Тус бааз нь 10 ажилчидтай ба хоногт дунджаар 0.8м$^3$ жилд 204м$^3$ орчим ус хэрэглэхээр байна. Дээрх тооцоог 1ажилчин өдөрт 80л ус хэрэглэнэ гэсэн тооцоололд үндслэн хийсэн.

*Хүснэгт 2. Ундны усны тооцоо*

| Хоногийн усны хэрэглээ, норм м$^3$ | Ажилчидын тоо | Жилд ажиллах хоног | Хоногийн усны хэрэглээ, м$^3$ | Жилийн усны хэрэглээ, м$^3$ |
|---|---|---|---|---|
| 0.08 | 10 | 255 | 0.8 | 204 |

**Ногоон байгууламжийн усны тооцоо:** МУ-ын Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн дагуу нийт эдэлбэр газрын 30%-тай тэнцэх талбайд ногоон байгууламж байгуулах тогтмол услаж байх хэрэгтэй. Ногоон байгууламж усалгааны хэрэглээг БОАЖЯ-ын сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 13 дугаар хавсралтанд зааснаар цэцэрлэг, зүлэг услах усалгааны норм 4л байна.

*Хүснэгт 3. Ногоон байгууламж, зам усалгааны тооцоо*

| **Зориулалт** | **Ногоон байгууламж, зам усалгааны тооцоо** | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Норм (л/м$^2$) | Талбай (м$^2$) | Хоногт услах хэмжээ м$^3$/хоног | Жилд услах хоног | Нийт жилд услах хэмжээ, м$^3$ |
| **Цэцэрлэг, зүлэг услах** | 0.004 | 30000 | 120 | 22 | 2640 |

*Хүснэгт 4. Ашиглах усны хэмжээ*

| № | Ус ашиглалтын хэлбэр | Усны эх үүсвэр | Ашиглах усны хэмжээ, /$м^3$/ | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Хоногт ашиглах усны хэмжээ | 1 жилд ашиглах усны хэмжээ | 5 жилд ашиглах усны хэмжээ |
| 1 | Ажилчдын унд ахуйн усны хэрэглээ | Гүний худаг | 0.8 $м^3$ | 204 $м^3$ | 1,025 $м^3$ |
| 2 | Ногоон байгууламж | | 120 $м^3$ | 2640 $м^3$ | 13200 $м^3$ |
| 3 | Нийт | | 120.09 $м^3$/хон | 2,653.77$м^3$/жил | 13,268.85$м^3$/5 жил |




***Зураг 9. Гүний худаг***

**Дулаан хангамж:** Тус төслийн талбай нь халаалтын хувьд цахилгаан халаагч хэрэгслийг ашиглаж байсан.

**Харилцаа холбоо:** Тус талбай нь харилцаа холбооны хувьд богино долгионы радио станц болон үүрэн телефоны утасны сүлжээ, мөн интернетийн сүлжээгээр бүрэн хангагдсан. Сансрын VSAT антенныг ашиглан телевизийн сувгуудыг хүлээн авах боломжтой.

**Зам харилцаа:**




***Зураг 10. Зам харилцаа төлөвлөлтийн зураг***

Тус бааз нь 1529м² хүчин чадалтай 318м урттай авто зам, 2619м² хүчин чадалтай 1870м явган хүний зам , 742м² хүчин чадалтай 125м урттай авто зогсоол,1543 м² хүчин чадалтай 772м урттай дугуй зам хийхээр төлөвлөсөн.

# 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

**Физик газарзүйн нөхцөл:** Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар нь улаанбаатар хотоос зүүн тийш 60 километрт оршдог. ГТБЦГ-т Төв аймгийн Эрдэнэ сум, Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрийн нийт 293168.0 га талбай хамрагдах ба Хэнтийн нурууны зүүн өмнөд хэсэгт байрлана.

Тус БЦГ-ын хамгийн хойд хэсэг нь Хан Хэнтийн ДЦГ болон ГТБЦГ-ын хилийн заагт оршдог Гэл уул (2550.8х.ө. 480251332, з.у. 1070381348), өмнөд цэг нь Гандан уулын ар, Туул голын урд эрэгт орших ба хойноосоо урагш 77км үргэлжилнэ. Баруун захын цэг нь Дархитын даваанаас баруун хойд зүгт орших 2045.6 тоот өндөрлөг (х.ө 480121465), зүүн захын цэг нь Юдэгийн даваа (1985.0, х.ө 480171747, з.у 10806169) ба баруунаас зүүн тийш 70км үргэлжилнэ.

Цогцолборт газрын хамгийн өндөр цэг нь Алтан- Өлгий уул (2645.7), хамгийн нам цэг нь Туул голын Бүдүүн чулууны гарам (1376.0) юм.

Ландшафт: Хэнтийн районы ландшафтын үндсэн хэв шинж бөгөөд гадаргын ихэнх хэсэгт тархсан байдаг. Тайгын ландшафт нь Хангай, Хөвсгөлийн уулын тайгын ландшафтыг бодвол өвөрмөц.

Уул хээрийн ландшафт: Төслийн талбайн урд захаар шинэс хусан ой бүхий уул хээрийн ландшафт голын эрэг рүү түрж орсон нам уулсаар тархсан. Төслийн талбайн ойр орчим гуу жалга багагүй байсан. Хад цохио цөөнгүй харин асга ховор.

Намагт нугын ландшафт: Намагт нугын ландшафт голуудын хөндий дагуу түүний өргөсөн хэсэг болон бэлчир орчмын тэгшивтэр гадаргад үүсэж тогтворжсон байдаг.

Төслийн талбай нь Хэнтийн нурууны байгалийн ойт хээрийн бүсэд хамаарч байна.

**Уур амьсгал:** Горхи тэрэлжийн БЦГ нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Уур амьсгалын үзүүлэлтүүд нь тэгш химийн хуваарилалттай,чийглэг зэврүүн зун, хахир өвөлтэй уур амьсгалын мужид багтах бөгөөд уур амьсгалын нөхцөлийн хувьд чийгийн хангамж 1- ээс их, нэмэх температурын нийлбэр буюу дулаан хангамж нь 15000С-ээс их нутаг болно.

ГТБЦГ нь хамгийн өндөр чийгшилтэй нутагт тооцогдоно. Хилд унах хур тунадасны нийлбэр олон жилийн дунджаар 350 орчим мм байхаас,95-97 хувь нь дулааны улиралд унах ба олон жилийн нийлбэрийн дундаж нь 100-120мм. 2021 оны байдлаар Тэрэлж өртөө орчим 345,7 мм хур тунадас унасан байна. үүнээс харахад төслийн талбай

орчим хур тунадас харьцангуй сайн ордог бүс нутагт хамаарна. 2021 оны байдлаар нийт орсон хур тунадасны 87,9% нь 5-9-р сарын хооронд бороо хэлбэрээр орсон байна. төслийн талбай орчим 2021 оны байдлаар хамгийн их хур тунадас орсон сар нь 7-р сар 94 мм бол хамгийн бага хур тунадас унасан сар нь 1-р сард 2,1 мм байна.

Харьцангуй чийгшил нь тухайн агаар чийгээр хангахад шаардагдах чийгийн хэмжээний хэдэн хувийг эзэлж байгааг илэрхийлнэ. Энэ нь тухайн газар нутгийн уур амьсгалын чийглэг буюу хуурай болохын шинж төлөвийг илэрхийлэх маш чухал үзүүлэлт бөгөөд түүнийг уур амьсгалын судалгаанд өргөн хэрэглэдэг.Харьцангуй чийгшил нь 7,12,1 саруудад их байдаг нь дулааны улирлын хур тунадас их ордогтой, өвөл манай оронд хүйтрэхэд агаарын чийг агуулах чадвар багасдагаар тайлбарлагдана. Жилийн дундаж харьцангуй чийгшил 70-75% хүрч хамгийн хуурай хаврын улиралд 45-55% байна. Энэ бүс нутагт хуурай өдөр 15-20 өдөр тохиолдож байхад 30-40 өдөр нь 80%-иас дээш чийгтэй байдаг. Зарим жилд өдрийн харьцангуй чийгшил 10%-иас доош орох тохиолдол гарч байсан байна.

**Геологийн тогтоц:** Хэнтий нуруу нь геологийн тогтцын хувьд нилээд цомхон боловч өвөрмөц дүрх төрхтэй. Хэнтий нуруунд анх төрмөл, эрт төрмөл, дунд төрмөлийн эриний настай гүний болон тунамал чулууулаг тархсан байна. Эрт төрмөлийн чулуун нүүрсний галавын нүүрст бх нүүрстөрөгчит шаварлаг занар, Туул, Заан голуудын эхэн сав газраар,девоны ангилагдуугүй чулуулаг, цахиурлаг занар, хас нүүрст ба нүүрстөрөгчит шаварлаг занар зэрэг чулуулаг Өвөр Минж, Туулын эх, Тэрэлжийн сав газраар тархсан байна. Хөрс үүсгэгч дөрөвдөгчийн аллюви, эллюви, делюви, пролюви, мөсдлийн хурдсууд Хэнтийд өргөн тархсан байдаг. Неоген, дөрөвдөгчийн хурдсууд уулс хоорондын хотгор, хонхор, голуудын хөндийг дүүргэсэн байдгаас гадна төвийн өндөр уулсын хавьд зарим хэсэгтээ аллюьийн хурдас, дөрөвдөгчийн өмнөх үеийн хурдас алаг цоог тархана.

**Гадаргын ус:** Төслийн талбай орчим нь гадаргын усны олон улсын ай савын ангиллаар манай орны хамгийн их гол мөрөнтэй гэгдэх Хойд мөсөн далайн ай савд багтана. Дотоодын гол мөрнүүдийн ай савын хувьд Чингэлтэйн уулсын өвөр хажуугаас Богдхан уул хүртэлх нутаг Туул голын ай савд багтах бол, Чингэлтэй уулын ар хажуугаас хойш орших нутаг нь Хараа голын ай савд багтана. Томоохон голууд нь Туул гол, түүний цутгал голууд болох Улиастайн гол, Сэлбийн гол, Гачууртын гол, Тэрэлжийн гол, Хуйн гол зэрэг болно. Мөн энэ бүс нутаг нь өндөр уул, ой ихтэй уулсын амнуудаар олон жижиг гол горхинууд улирлын шинжтэй урсах болон, бороо хур элбэгтэй жилүүдэд байнга урсацтай болох нь элбэг. Энэ бүсэд голын сүлжээний нягтшил

0,1-0,5 км/км$^2$ байгаа нь манай орны нийт нутгийн дунджаас дээгүүр үзүүлэлт юм. Гадаргын усны урсцын хэмжээ нь 60-90 мм байна. Гадаргын уулархаг байдлаас шалтгаалан томоохон тогтоол ус, нуур тогтоогүй байна.

**Хөрсөн бүрхэвч:** Төслийн талбай орчмын бүс нутаг нь газрын гадаргын хувьд Налайх орчмын хаяа уулсын системд хамаарагдах нам уулсын системд байрлана. Тус судалгааны талбай нь хөрс газарзүйн мужлалаар хөрс-био уур амьсгалын их мужийн холимог бүсчлэл бүхий Хангайн их мужийн өндрийн бүсшилтэй нутаг хэв шинжийн Хэнтийн захын буюу 39-р тойрогт багтана. Уулын нугын болон уулын ойн ширэгт хөрс, ойн доод хил орчмоор уулын болон нугат хар хүрэн хөрс, уулсын бэл хажуу хэсгээр хар хүрэн, голын хөвөө орчмын өндөрлөг, төв татмын өндөрлөг газраар доод аллювийн ширэгт хөрс зонхилно.

**Амьтны аймаг:** Амьтны аймгийн хувьд Налайх хотын нутаг дэвсгэрийн төв болон баруун хэсэгт амьтны аймгийн төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно. Тухайлбал шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн (P.domesticus) ба хээрийн (P.montanus) бор шувуу, хөхвөр тагтаа (C.livia), Сохор элээ (Milvus migrans), Шаазгай (Pica pica), Улаан хошуут (Pyrrhcorax pyrrhocorax), Хар хэрээ (Corvus corone), Хон хэрээ (Corvus corax) арай олон үзэгдэнэ. Хөхтний дотроос дагуур зурам, хэргэлзий оготно, үлийн цагаан оготно, гэрийн хулгана нутагшиж байна. Шавжийн ангиас ихэвчлэн төрөл бүрийн цохын овог таарална.

# 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

**Агаар орчинд үзүүлэх нөлөөлөл:**

- Автотээврийн хэрэгслээс ялгарах хорт хий
- Тоос, тоосонцор нь тунадасжин бууж хөрс, гүний усанд орж тархах, бохирдуулах
- Тоосжилт ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх

**Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл:**

- Тээврийн хөдөлгөөнөөс хөрсний эвдрэл үүсгэх
- Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор газрын гадарга эвдэгдэх
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- Тоос хөрсөнд хуримтлагдаж бохирдол үүсэх

**Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл:**

- Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор ургамлан нөмрөг талхлагдах
- Тээврийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт ургамлан нөмрөгт дам нөлөөлөл үзүүлэх
- Барилгын ажлын үед үүсэх барилгын хог хаягдалд ургамлан нөмрөг талхлагдах

**Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл:**

- Төслийн үйл ажиллагаанд өртсөн талбайн ургамлан нөмрөг устах бөгөөд үүнийг даган бичил амьтад ч мөн амьдрах орчноосоо дайжна.
- Дуу чимээ, тоосны бохирдол, амьтны нүх, үүрэнд шууд нөлөөлснөөр амьдрах орчинд сөргөөр нөлөөлнө.
- Ургамлан нөмрөгт төслийн үйл ажиллагааны явцад ялгарсан, асгарсан бохирдуулагч материалууд хуримтлагдсанаас өвсөн тэжээлтэн амьтад хордох
- Төслийн үйл ажиллагаанаас бий болох хог хаягдлыг эмх замбараагүй хаяснаар амьтдын амьдрах орчин бохирдох, зарим зүйл амьтан хордох магадлалтай.
- Амьтдын амьдрах орчин хуваагдах

**Дуу чимээний үзүүлэх нөлөөлөл:**

- Төслийн үйл ажиллагаа эхэлснээр үүсэх дуу чимээ нь ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх
- Нутгийн оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах
- Амьтдад ойр орчмоос дайжих

# 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны 2024 оны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний менежментийн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах зэрэг арга хэмжээнүүдийг тус тус хэрэгжүүлсэн байна.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг удирдлага болголоо.

2024 оны БОМТ-д тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэхэд нийт 9443700 төгрөгөөр хийж гүйцэтгэлээ. Үүнд: хог хаягдалын уут, газ-800 мян.төг, орчны тохижилт 2.0 сая.төг машин түрээс-838.7 мян.төг, бохир ус зайлуулах 4.185 сая.төг, тоосноос хамгаалах амны маск, хэрэгсэл -200.0 мян.төг, хөрсний дээж, газрын хянан баталгааны ажил- 2.0 сая.төг, хог тээвэр-220.0 мян.төг

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

*Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжилт | Тайлбар | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|
| 1 | Горхи тэрэлжийн авто машины хөдөлгөөн ихэссэнээс агаар, агаар дахь тоосны хэмжээ, утаа, тортог, бохирдол үүсэх, тоосжилт үүсэх | Барилгажилт, бүтээн байгуулалтын үед ажиллах ажиллагсдад тоосноос хамгаалах хушуувч, амны маск зэргээр ажилчдыг хангах | Бүрэн хэрэгжсэн | Ажилчдад орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн болон бүтээн байгуулалтын үед тоосноос хамгаалах амны маск, хэрэгслээр хангаж ажилласан. |  |
| 2 | Хөрсний эвдрэл, гэмтэл | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх | Бүрэн хэрэгжсэн | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 2024 онд мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн. |  |

УЛААНБААТАР (11) ХОТ, НАЛАЙХ (13) ДҮҮРГИЙН 6-Р ХОРООНЫ НУТАГТ БАЙРЛАХ "АЛТАНТУР" ХХК-ИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗ ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2024 он

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ

**Хянан баталгааны төрөл:** Захиалгат хянан баталгаа **Огноо:** 2024-12-19
1. **Газар ашиглагч:** Алтантур ХХК
2. **Аймаг (нийслэл):** Улаанбаатар **Сум (дүүрэг):** Налайх
3. **Байршил, хаяг:** 6-р хороо, Шилэрзогийн ам /12712/, 701
4. **Нэгж талбарын дугаар:** 1260811225
5. **Хөрсний нэр:** 1502- Уулын хар хүрэн хөрс
6. **Ургамалжилт:** УХ-II-2-1 Үетэн-улалж-алаг өвс
7. **Нийт талбайн хэмжээ:** 49974 м²
8. **Газар эзэмших зориулалт:** Аялал, жуулчлалын бааз
9. **Одоогийн газар ашиглалтын хэлбэр:** Аялал, жуулчлалын бааз
10. **Газар ашиглах, эзэмших шийдвэр:** Улаанбаатар аймаг /нийслэл/-ийн Налайх сум/дүүргийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 25-ний өдрийн 01113-А/398/2021 тоот захирамж
11. **Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар:** 2009/918
12. **Эзэмшил газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт**

Газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт

| Газар ашиглалтын байдал | Талбай | Эвдэрч бохирдсон талбай | | |
|---|---|---|---|---|
| | | Физикийн | Химийн | Биологийн |
| Нийт эзэмшил газар | 49974 | - | - | - |
| Нэгж талбарын талбай | 49974 | - | - | - |
| Газар дээрээ ашиглаж байгаа талбай | 48320 | - | - | - |
| Дутуу ашиглаж байгаа газар | 12069 | - | - | - |
| Илүү ашиглаж байгаа газар | 10415 | - | - | - |
| **А.Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай** | | | | |
| **1.Үйл ажиллагаанд өртөөгүй талбай** | | | | |
| **2.Үйл ажиллагаанд өртсөн талбай** | | | | |
| амрагчдын гэр сууц | 800 | + | - | - |
| амралтын төв байр | 583 | + | - | - |
| сагсан бөмбөгийн талбай | 187 | + | - | - |
| суудрын | 21 | + | - | - |
| амрагчдын байшин | 288 | + | - | - |
| хүүхдийн тоглоомын талбай | 25 | + | - | - |
| явган хүний зам | 592 | + | - | - |
| **Б.Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа талбай** | | | | |
| **1.Үйл ажиллагаанд өртөөгүй талбай** | | | | |
| сул чөлөөтэй газар | 10329 | - | - | - |
| **2.Үйл ажиллагаанд өртсөн талбай** | | | | |
| контейнер | 50 | + | - | - |
| суудрын | 36 | + | - | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | БАТАЛГААЖСАН.<br>ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР /Гэрээт ажилтан/ |
| 3 | | Орчны тоосжилт болон салхины хурд, дуу чимээг бууруулах болон салхинаас хамгаалах зорилгоор мод бут тарих | Бүрэн хэрэгжсэн | Аялал жуулчлалын баазын төслийн талбайд орчны тоосжилт, салхинаас хамгаалах зорилгоор мод бутыг тарьж ургуулсан. |     |

**Шилжүүлгийн мэдээлэл**
**Журналын № : 891000584210**

Системийн огноо: **2024.05.24 11:24:32**

Нэр : **АЛТАНТУР ХХК**

| | | | | |
|---|---|---|---|---|
| Илгээгч | Дансны дугаар: **405079954** | Нэр **АЛТАНТУР ХХК** | Дүн **838,750.00 MNT** | Ханш **1** |
| Хүлээн авагч | Банкны дугаар: **04**<br>Дансны дугаар: **413014829** | Банкны нэр **Худалдаа Хөгжлийн Банк**<br>Нэр **ГЭБЭТ ХХК** | **838,750.00 MNT** | **1** |
| Гүйлгээний утга: **ЕВ -Алтантур ХХК рег:2703181 машин түрээс** | | | | |

**Танд баярлалаа**

Дансны тодорхойлолтыг QR код болон дараах холбоосоор хандаж баталгаажуулна уу.
https://www.etdbm.mn/verify.php
Баталгаажуулах код: 4D710817EB4A0366

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | | Төслийн талбай дахь гадна, дотор байрлуулсан бүх хогийн савыг өдөр бүр суллан цэвэрлэх | Бүрэн хэрэгжсэн | Төслийн талбайн хогийн савыг өдөр бүр цэвэрлэж, тогтсон хугацаанд хог хаягдлыг тээвэрлүүлсэн. |  |
| 5 | | Төслийн орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийх, төслийн хашаанаас гадна талбайд олон салаа зам гаргахаас сэргийлэх | Бүрэн хэрэгжсэн | Төслийн талбайн гадна тэмдэг, тэмдэгжүүлэлтийг хийсэн. |  |
| 6 | Зонхилох ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, талхагдал өөрчлөлт | Төслийн төлөвлөгөөнд тусгагдсан талбайд мод, бут сөөг тарьж, орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | Бүрэн хэрэгжсэн | Төслийн талбайд мод, бут сөөг тарьж, орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. |  |

# 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Хэрэгжилт | Тайлбар | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|
| 1 | Төслийн талбайд ногоон байгууламжтай болсоноор агаарын тоосжилт буурах зорилттой / Тэрбум мод төслийг хэрэгжүүлэх/ | Төслийн талбайн арын хэсгийн сул талбайг ногоон байгууламж болгох | Бүрэн хэрэгжсэн | Төслийн талбайн арын хэсгийн сул талбайг ногоон байгууламжтай болгосон. Явган хэсгийн зам талбайг хатуу хучилттай болгож тохижуулсан. |  |
| 2 | | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн талбайд мод тарих | Бүрэн хэрэгжсэн | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн талбайд мод тарьсан. |   |
| 3 | | Гэрэлтүүлэг нэмэх | Бүрэн хэрэгжсэн | Төслийн талбайн шаардлагатай аялагч, амрагчдын зорчих зам, талбайд гэрэлтүүлгүүдийг нэмж ажилласан. |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | |  |

## 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул 2024 оны БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

## 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн талбайд палеонтлогийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна. Үйл ажиллагааны явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулна.

## 9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Болзошгүй аюул, осол,сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Хэрэгжилт | Тайлбар | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|
| 1 | Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх | Галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх галын сараа байгуулах | Бүрэн хэрэгжсэн | Гамшгаас урьдчилан сэргийлэх галын сараа байгуулсан. |  |
| 2 | | Гэнэтийн ослоос урьдчилан хамгаалах төлөвлөөгөөтэй байх | Бүрэн хэрэгжсэн | Ажиллагсдад ХАБЭА-н чиглэлээр зааварчилгаа өгч ажилласан. |   |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | | Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах | Бүрэн хэрэгжсэн | Байгаль орчныг хамгаалах сургалтыг жилд 1 удаа зохион байгуулсан. |  |
| 4 | | Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах | Бүрэн хэрэгжсэн | Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулсан. | <br>АЖЛЫН БАЙРНЫ ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ<br>Дугаар 2023862<br>Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: "АЛТАН ТУР" ХХК<br>Хаяг: НАЛАЙХ ДҮҮРГИЙН 6 ДУГААР ХОРОО<br>Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: ЖУУЛЧНЫ БААЗ<br>Олгосон: 2021 он 07 сар 26 өдөр<br>Хүчинтэй хугацаа: 2023 он 07 сар 26 өдөр хүртэл<br>Дүгнэлт олгосон: НАЛАЙХ ДҮҮРГИЙН аймаг, нийслэлийн ... дарга ХУРАНДАА цолтой Л.ЧИНБАТ<br>Дүгнэлт гаргасан: НАЛАЙХ ДҮҮРГИЙН аймаг, нийслэлийн ... Гал түймрийн улсын хяналтын байцаагч АХМАД цолтой Б.ЭНЭЙСАЙХАН<br>/тэмдэг дарна/ |

## 10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

<table>
<tr><th>№</th><th>Хог хаягдлын ангилал</th><th>Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ</th><th>Хэрэгжилт</th><th>Тайлбар</th><th>Гүйцэтгэл</th></tr>
<tr><td>1</td><td rowspan="3">Ахуйн хог хаягдал</td><td>Ахуйн хаягдлыг ангилах дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх</td><td>Бүрэн хэрэгжсэн</td><td rowspan="3">Хог хаягдлыг 2024 оны 06 сарын 20-ний өдөр Налайх Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-тэй гэрээ байгуулан тогтмол тээвэрлүүлж байна.</td><td rowspan="3">  <br>ГОЛОМТ БАНК<br>Цахим гүйлгээний баримт<br>Хүсэлтийн лавлах дугаар: S23892176202409303 Татсан огноо: 2025-03-12 11:22<br>Шилжүүлэгчийн дансны дугаар: 1102039913 MN630015001102039913<br>Хүлээн авагчийн данс: 5749062084<br>Гүйлгээний дүн: 220,000.00 MNT<br>Гүйлгээний төлөв: Амжилттай<br>Шилжүүлэгчийн нэр: АЛТАНТУР ХХК<br>Хүлээн авагчийн нэр: НАЛАЙХТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ<br>Гүйлгээний утга: АЛТАНТУР ХХК. РЕГ:2703181 ХОГ ТЭЭВ ЭРТ,<br>Хүлээн авагчийн банк: ХААН ТӨВ БАНК<br>Гүйлгээний огноо: 2024-09-30<br>ГОЛОМТ БАНК 01 ХУУЛБАР ҮНЭН<br>Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.</td></tr>
<tr><td>2</td><td>Хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх, үйлчилгээний гэрээ хийх</td><td>Бүрэн хэрэгжсэн</td></tr>
<tr><td>3</td><td>Хог хаягдлыг тухай бүрд тээвэрлэж зайлуулж байх</td><td>Бүрэн хэрэгжсэн</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | | Гадна талбайд хогийн сав байрлуулах | Бүрэн хэрэгжсэн | Гадна талбайд хогийн савыг байршуулсан. | |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Шингэн хаягдал | Бохирын цооногийн орчны ариутгал халдваргүйжүүлэлтийг цаг тухайд нь хийх | Бүрэн хэрэгжсэн | Бохир усыг хугацаанд нь тээвэрлүүлэн ажилласан. | |



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

Огноо: **2024.07.29**

**Шилжүүлгийн мэдээлэл**
**Журналын № : 897600820923**

Системийн огноо: **2024.07.29 15:49:25**

Нэр : **АЛТАНТУР ХХК**

| | | | | |
|---|---|---|---|---|
| Илгээгч | Дансны дугаар: **405079954** | Нэр **АЛТАНТУР ХХК** | Дүн **1,215,000.00 MNT** | Ханш **1** |
| Хүлээн авагч | Банкны дугаар: **050000** Дансны дугаар: **5009952783** | Банкны нэр **Хаан Банк** Нэр **МАРГАД ЭРДЭНЭ УУЛ** | **1,215,000.00 MNT** | **1** |

Гүйлгээний утга:
**ЕВ -Алтантур ХХК. рег:2703181 бохир ус татав**

**Танд баярлалаа**

Дансны тодорхойлолтыг QR код болон дараах холбоосоор хандаж баталгаажуулна уу.
https://www.etdbm.mn/verify.php
Баталгаажуулах код: 6955FC71A9D674F4



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

Огноо: **2024.09.17**

**Шилжүүлгийн мэдээлэл**
**Журналын № : 902601023022**

Системийн огноо: **2024.09.17 16:58:34**

Нэр : **АЛТАНТУР ХХК**

| | | | | |
|---|---|---|---|---|
| Илгээгч | Дансны дугаар: **405079954** | Нэр **АЛТАНТУР ХХК** | Дүн **675,000.00 MNT** | Ханш **1** |
| Хүлээн авагч | Банкны дугаар: **050000** Дансны дугаар: **5009952783** | Банкны нэр **Хаан Банк** Нэр **МАРГАД ЭРДЭНЭ УУЛ** | **675,000.00 MNT** | **1** |

Гүйлгээний утга:
**ЕВ -Алтантур ХХК. рег:2703181 бохир ус зайлуулах төлбөрт**

**Танд баярлалаа**

Дансны тодорхойлолтыг QR код болон дараах холбоосоор хандаж баталгаажуулна уу.
https://www.etdbm.mn/verify.php
Баталгаажуулах код: 5D1F991B3F812E42



ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

**Цахим гүйлгээний баримт**

Хүсэлтийн лавлах дугаар: S98638217202408313 Татсан огноо: 2025-03-12 11:14

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| **1102039913** MN630015001102039913 | **5009952783** | **2,295,000.00 MNT** | **Амжилттай** |
| Шилжүүлэгчийн нэр **АЛТАНТУР ХХК** | Хүлээн авагчийн нэр **МАРГАД ЭРДЭНЭ УУЛ** | Гүйлгээний утга **АЛТАНТУР ХХК. РЕГ:2703181 БОХИР ТА ТАЛТ** | |
| | Хүлээн авагчийн банк **ХААН ТӨВ БАНК** | Гүйлгээний огноо **2024-08-31** | |

ГОЛОМТ БАНК 01 ХУУЛБАР ҮНЭН

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

## 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

*Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хэрэгжилт | Тайлбар | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хөрсний агрохими | Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх | Бүрэн хэрэгжсэн | Хөрсний агрохимийн дээжийг 2024 оны 11 сарын 19-ний өдөр дээж авч "Инженер геодези" ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. |     |
| 2 | Хөрсний механик бүрэлдэхүүн | Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх | Бүрэн хэрэгжсэн | Хөрсний механик бүрэлдэхүүний дээжийг 2024 оны 11 сарын 19-ний өдөр дээж авч "Инженер геодези" ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. | |
| 3 | Хүнд металлын агууламж | Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох | Бүрэн хэрэгжсэн | Хөрсний хүнд металлын дээжийг 2024 оны 11 сарын 19-ний өдөр дээж авч "Инженер геодези" ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. | |
| 4 | Хөрсний эрүүл ахуй | Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох | Бүрэн хэрэгжсэн | Хөрсний эрүүл ахуйн дээжийг 2024 оны 11 сарын 19-ний өдөр дээж авч "Инженер геодези" ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | лабораторид шинжлүүлсэн. | |

## 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт*

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Хэрэгжилт | Тайлбар | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх | Бүрэн хэрэгжсэн | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журмыг боловсруулан мөрдөж ажиллаж байна. |   |
| 2 | Хог хаягдлын ангилан ялгах боломжтой хогийн сав байршуулах | Бүрэн хэрэгжсэн | Хог хаягдлын ангилан ялгах боломжтой хогийн савыг байршуулсан. |  |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах | Бүрэн хэрэгжсэн | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж төслийн барилга байгууламжийн үед ажилласан. |  |
| 4 | Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах | Бүрэн хэрэгжсэн | Галын аюулаас хамгаалах хэрэгсэлээр бүрэн хангасан. |  |

# 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт*

| № | БОМТ, БОМТ-ийн хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээний агуулга | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Горхи тэрэлжийн байгалийн цогцолбор газарт танилцуулах | БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумдын засаг захиргаанд хүргүүлнэ. | БОМТ-ний биелэлт | 2024 оны БОМТ-ийн биелэлтийн тайланг боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А/618 тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын дагуу боловсруулж хүлээлгэн өгч ажиллаж байна. |
| 2 | БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Горхи тэрэлжийн байгалийн цогцолбор газрын оршин суугчдад танилцуулж хэлэлцүүлнэ. | Нутгийн оршин суугчдад БОМТ-ний биелэлтийг тайлагнах | | |
| 3 | Горх-Тэрэлжийн БЦГ-ын Хамгаалалтын захиргаанд БОМТ танилцуулах | БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж тайлагнах | | |

Огноо: **2024.05.10**

## Шилжүүлгийн мэдээлэл
## Журналын № : 889600878232

Системийн огноо: **2024.05.10 14:30:11**

Нэр : **АЛТАНТУР ХХК**

| | | | Дүн | | Ханш |
|---|---|---|---|---|---|
| Илгээгч | Дансны дугаар:<br>**405079954** | Нэр<br>**АЛТАНТУР ХХК** | **290,000.00** | **MNT** | **1** |
| | | | | | |
| Хүлээн авагч | Банкны дугаар:<br>**050000**<br>Дансны дугаар:<br>**5319012975** | Банкны нэр<br>**Хаан Банк**<br>Нэр<br>**НАМЖИЛЖАВ ЛХАГВАСҮРЭН** | **290,000.00** | **MNT** | **1** |
| Гүйлгээний утга:<br>**ЕВ -Гялгар уут** | | | | | |

**Танд баярлалаа**

Дансны тодорхойлолтыг QR код болон дараах холбоосоор хандаж баталгаажуулна уу.
https://www.etdbm.mn/verify.php
Баталгаажуулах код: 26DC7CD28FAFCC8D

TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

Огноо: **2024.05.12**

# Шилжүүлгийн мэдээлэл
## Журналын № : 889801142021

Системийн огноо: **2024.05.12 22:17:07**

Нэр : **АЛТАНТУР ХХК**

| | | | Дүн | | Ханш |
|---|---|---|---|---|---|
| Илгээгч | Дансны дугаар:<br>**405079954** | Нэр<br>**АЛТАНТУР ХХК** | **508,200.00** | **MNT** | **1** |
| | | | | | |
| Хүлээн авагч | Банкны дугаар:<br>**050000**<br>Дансны дугаар:<br>**5779499109** | Банкны нэр<br>**Хаан Банк**<br>Нэр<br>**АСЫЛХАН САЯРХАН** | **508,200.00** | **MNT** | **1** |
| Гүйлгээний утга:<br>**EB -Алтантур ХХК 2703181 газны төлбөрт төлөв** | | | | | |

## Танд баярлалаа

Дансны тодорхойлолтыг QR код болон дараах холбоосоор хандаж баталгаажуулна уу.
https://www.etdbm.mn/verify.php
Баталгаажуулах код: 67ABA9146CC56FB0

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

Огноо: **2024.05.24**

# Шилжүүлгийн мэдээлэл
## Журналын № : 891000584210

Системийн огноо: **2024.05.24 11:24:32**

Нэр : **АЛТАНТУР ХХК**

| | | | Дүн | | Ханш |
|---|---|---|---|---|---|
| Илгээгч | Дансны дугаар: **405079954** | Нэр **АЛТАНТУР ХХК** | **838,750.00** | **MNT** | **1** |
| | | | | | |
| Хүлээн авагч | Банкны дугаар: **04**<br>Дансны дугаар: **413014829** | Банкны нэр **Худалдаа Хөгжлийн Банк**<br>Нэр **ГЭБЭТ ХХК** | **838,750.00** | **MNT** | **1** |

Гүйлгээний утга:
**ЕВ -Алтантур ХХК рег:2703181 машин түрээс**

## Танд баярлалаа

Дансны тодорхойлолтыг QR код болон дараах холбоосоор хандаж баталгаажуулна уу.
https://www.etdbm.mn/verify.php
Баталгаажуулах код: 4D710817EB4A0366

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

Огноо: **2024.07.29**

## Шилжүүлгийн мэдээлэл
## Журналын № : 897600820923

Системийн огноо: **2024.07.29 15:49:25**

Нэр : **АЛТАНТУР ХХК**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Илгээгч | Дансны дугаар:<br>**405079954** | Нэр<br>**АЛТАНТУР ХХК** | Дүн<br>**1,215,000.00** | **MNT** | Ханш<br>**1** |
| | | | | | |
| Хүлээн авагч | Банкны дугаар:<br>**050000**<br>Дансны дугаар:<br>**5009952783** | Банкны нэр<br>**Хаан Банк**<br>Нэр<br>**МАРГАД ЭРДЭНЭ УУЛ** | **1,215,000.00** | **MNT** | **1** |
| Гүйлгээний утга:<br>**ЕВ -Алтантур ХХК. рег:2703181 бохир ус татав** | | | | | |

## Танд баярлалаа

Дансны тодорхойлолтыг QR код болон дараах холбоосоор хандаж баталгаажуулна уу.
https://www.etdbm.mn/verify.php
Баталгаажуулах код: 6955FC71A9D674F4

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

Огноо: **2024.09.17**

# Шилжүүлгийн мэдээлэл
## Журналын № : 902601023022

Системийн огноо: **2024.09.17 16:58:34**

Нэр : **АЛТАНТУР ХХК**

| | | | | |
|---|---|---|---|---|
| Илгээгч | Дансны дугаар: **405079954** | Нэр **АЛТАНТУР ХХК** | Дүн **675,000.00 MNT** | Ханш **1** |
| | | | | |
| Хүлээн авагч | Банкны дугаар: **050000**<br>Дансны дугаар: **5009952783** | Банкны нэр **Хаан Банк**<br>Нэр **МАРГАД ЭРДЭНЭ УУЛ** | **675,000.00 MNT** | **1** |
| Гүйлгээний утга: **ЕВ -Алтантур ХХК. рег:2703181 бохир ус зайлуулах төлбөрт** | | | | |

## Танд баярлалаа

Дансны тодорхойлолтыг QR код болон дараах холбоосоор хандаж баталгаажуулна уу.
https://www.etdbm.mn/verify.php
Баталгаажуулах код: 5D1F991B3F812E42

# ГОЛОМТ БАНК
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

# Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: **S98638217202408313**

Татсан огноо: **2025-03-12 11:14**

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| **1102039913**<br>**MN630015001102039913** | **5009952783** | **2,295,000.00 MNT** | **Амжилттай** |

| | | |
|---|---|---|
| Шилжүүлэгчийн нэр<br>**АЛТАНТУР ХХК** | Хүлээн авагчийн нэр<br>**МАРГАД ЭРДЭНЭ УУЛ** | Гүйлгээний утга<br>**АЛТАНТУР ХХК. РЕГ:2703181  БОХИР ТА ТАЛТ** |
| | Хүлээн авагчийн банк<br>**ХААН ТӨВ БАНК** | Гүйлгээний огноо<br>**2024-08-31** |

01 ГОЛОМТ БАНК ХУУЛБАР ҮНЭН

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

ГОЛОМТ БАНК
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

# Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: **S23892176202409303**

Татсан огноо: **2025-03-12 11:22**

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| **1102039913**<br>**MN630015001102039913** | **5749062084** | **220,000.00 MNT** | **Амжилттай** |

| | | |
|---|---|---|
| Шилжүүлэгчийн нэр<br>**АЛТАНТУР ХХК** | Хүлээн авагчийн нэр<br>**НАЛАЙХТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ** | Гүйлгээний утга<br>**АЛТАНТУР ХХК. РЕГ:2703181 ХОГ ТЭЭВ ЭРТ,** |
| | Хүлээн авагчийн банк<br>**ХААН ТӨВ БАНК** | Гүйлгээний огноо<br>**2024-09-30** |

01 ГОЛОМТ БАНК ХУУЛБАР ҮНЭН

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.